

“ТӨРӨӨС ТӨМӨР ЗАМЫН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО”-ЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

“Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль, нийслэлийн дунд хугацааны хөгжлийн бодлогод нийцүүлэн томоохон бүтээн байгуулалтыг санхүүжүүлэх, олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, гадаад зээл тусламжийн төслүүдийг хугацаанд нь дуусгаж ашиглалтад оруулах, төслүүдийн үр ашиг, гүйцэтгэлийг хангах зорилгоор гадаад зээл тусламжийн төслүүдийг эрэмбэлж, ач холбогдол нь улс орны эдийн засагт эерэгээр нөлөөлөх төслүүдийн ашиглалтыг ирэх дөрвөн жилд бүрэн хэрэгжүүлэх хүрээнд Төмөр замын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ын 4.1.2 заалтыг тус тус үндэслэн Төмөр замын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ын 4.1.2 заалтыг тус тус үндэслэн боловсруулсан болно.

Эдийн засагт эерэгээр нөлөөлөх төслүүдийн ашиглалтыг ирэх дөрвөн жилд бүрэн хэрэгжүүлэх хүрээнд “ХУРДАЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ЗОРИГ” Хамтарсан Засгийн газрын гэрээ, хамтын ажиллагааны зарчим, хүрээ, тэргүүлэх чиглэл, хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг тодорхойлсон. Уг гэрээнд үндэслэн Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулж, Монгол Улсын хөгжлийн тулгамдсан асуудал, сорилтыг шийдвэрлэх, эдийн засгийн суурийг тэлэх эрчим хүч, дэд бүтэц, аж үйлдвэржилтийн томоохон төслүүдийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага бий боллоо.

Монгол улсын эдийн засгийн бүтэц нь уул уурхайгаас хамааралтай хэвээр байгаа бөгөөд энэ байдал ойрын жилүүдэд өөрчлөгдөхгүй юм. Эдийн засгаа солонгоруулахын тулд бусад салбарт оруулах хөрөнгө оруулалт чухал юм. Ийм боломжийг Монгол улсын экспортын бүтээгдэхүүнийг бага зардлаар уул уурхайн бүтээгдэхүүний үнэ өндөр байгаа энэ цаг хугацаанд хийх ёстой. Иймээс төмөр замын шинэ шугам баригдаж ашиглалтад орсноор төмөр замын тээврийн өндөр үр ашигтай, алдагдалгүй систем бүрдэж эдийн засагт чухал нөлөө үзүүлэхийн хамт дамжин өнгөрөх тээвэр илүү хөгжих ажлын байр шинээр нэмэгдэх нөхцөл бүрдэх юм. Уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэхийн тулд төмөр замын тээн нэвтрүүлэх хүчин чадлыг дээшлүүлж, уул уурхайн бүтээгдэхүүн, дамжин өнгөрүүлэх ачаа тээвэр болон экспорт, импортын ачаа эргэлтийг үр дүнтэй хангах тээвэрлэлтийн оновчтой зохион байгуулалт бүхий төмөр замын дотоодын нэгдсэн сүлжээтэй болох асуудал тулгараад байгаа билээ.

Далайд гарцгүй Монгол Улсын хувьд хөрш орнууддаа, цаашлаад тэдгээрээр дамжин далайд хүрч гуравдагч улсуудад бараа, бүтээгдэхүүнээ ашигтай нөхцөлөөр экспортлохын тулд зөвхөн төмөр замын дотоодын оновчтой зохион байгуулалт бүхий нэгдсэн сүлжээтэй болохоос гадна төмөр замаар хөрш улсуудын нутгаар дамжин өнгөрөх төмөр замын бүтээн байгуулалтын дүнд ОХУ болон БНХАУ-ын төмөр замуудтай холбогдох шинэ гарц нээгдэнэ.

“Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-д бүтээгдэхүүн нь экспортод шууд тээвэрлэгдэх ашигт малтмалын ордоос хилийн боомт хүрэх ачаа тээвэрлэлтийн зориулалттай төмөр замын шугамын царигийн өргөнийг Засгийн газар Улсын Их Хуралд танилцуулж шийдвэрлүүлэхээр заасан байдаг.

“Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох хуулиуд, Улсын Их Хурлын холбогдох тогтоолуудтай нийцсэн болно. Тогтоолын төсөлтэй холбогдуулан Монгол Улсын хуулиуд болон Улсын Их хурлын тогтоолд нэмэлт, өөрчлөлт орохгүй болно.

“Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл нь 2 зүйлтэй байх бөгөөд төсөлд дараах асуудлыг тусгасан болно. Үүнд:

1 дүгээр зүйлд: Экспортод шууд тээвэрлэгдэх ашигт малтмалын ордоос хилийн боомт хүрэх ачаа тээврийн зориулалттай төмөр замын шугамын цариг нь импортлогч оронд тавигдсан царигтай тохирч байхаар;

2 дугаар зүйлд: “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэрэгжилтэд хяналт тавих талаар тус тус тусгасан.

“Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл батлагдсанаар дараах нийгэм, эдийн засаг, хууль зүйн зэрэг үр дагавар үүснэ гэж үзэж байна. Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулж, Монгол Улсын хөгжлийн тулгамдсан асуудал, сорилтыг шийдвэрлэх, эдийн засгийн суурийг тэлэх эрчим хүч, дэд бүтэц, аж үйлдвэржилтийн томоохон төслүүдийг үр дүнтэй хэрэгжүүлэх боломж нээгдэх юм.

“ТӨРӨӨС ТӨМӨР ЗАМЫН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО”-ЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол улсын эдийн засгийн бүтэц нь уул уурхайгаас хамааралтай хэвээр байгаа бөгөөд энэ байдал ойрын жилүүдэд өөрчлөгдөхгүй юм. Эдийн засгаа солонгоруулахын тулд бусад салбарт оруулах хөрөнгө оруулалт чухал юм. Ийм боломжийг Монгол улсын экспортын бүтээгдэхүүнийг бага зардлаар уул уурхайн бүтээгдэхүүний үнэ өндөр байгаа энэ цаг хугацаанд хийх ёстой. Иймээс төмөр замын шинэ шугам баригдаж ашиглалтад орсноор төмөр замын тээврийн өндөр үр ашигтай, алдагдалгүй систем бүрдэж эдийн засагт чухал нөлөө үзүүлэхийн хамт дамжин өнгөрөх тээвэр илүү хөгжих ажлын байр шинээр нэмэгдэх нөхцөл бүрдэх юм.

Монгол улсын стратегийн ач холбогдол бүхий нүүрс болон бусад ашигт малтмалын ордууд ашиглалтад орсноор экспортод гаргах бүтээгдэхүүний хэмжээ жилд дунджаар өнөөдөр ашиглаж буйгаас 3.5 дахин нэмэгдэх тойм тооцоо байна.

Уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэхийн тулд төмөр замын тээн нэвтрүүлэх хүчин чадлыг дээшлүүлж, уул уурхайн бүтээгдэхүүн, дамжин өнгөрүүлэх ачаа тээвэр болон экспорт, импортын ачаа эргэлтийг үр дүнтэй хангах тээвэрлэлтийн оновчтой зохион байгуулалт бүхий төмөр замын дотоодын нэгдсэн сүлжээтэй болох асуудал тулгараад байгаа билээ. Далайд гарцгүй Монгол Улсын хувьд хөрш орнууддаа, цаашлаад тэдгээрээр дамжин далайд хүрч гуравдагч улсуудад бараа, бүтээгдэхүүнээ ашигтай нөхцөлөөр экспортлохын тулд зөвхөн төмөр замын дотоодын оновчтой зохион байгуулалт бүхий нэгдсэн сүлжээтэй болохоос гадна төмөр замаар хөрш улсуудын нутгаар дамжин өнгөрөх төмөр замын бүтээн байгуулалтын дүнд ОХУ болон БНХАУ-ын төмөр замуудтай холбогдох шинэ гарц нээгдэнэ. “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-д бүтээгдэхүүн нь экспортод шууд тээвэрлэгдэх ашигт малтмалын ордоос хилийн боомт хүрэх ачаа тээвэрлэлтийн зориулалттай төмөр замын шугамын царигийн өргөнийг Засгийн газар Улсын Их Хуралд танилцуулж шийдвэрлүүлэхээр заасан байдаг. “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл батлагдсанаар дараах нийгэм, эдийн засаг, хууль зүйн эерэг үр дагавар үүснэ гэж үзэж байна.